

ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛ: НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ҮР ДАГАВАР

(Үргэлжлэл. Турууч нь өмнөх дугааруудад)

Ц.Баатар

Өмнөх цуврал өгүүллүүддээ бид глобалчлалын эриний олон улсын худалдаа, санхүү, үндэстэн дамнасан корпораци, олон улсын харилцаа, буурай хөгжилтэй орнуудын хөгжлийн зарим асуудлуудын талаар тоймлон өгүүлсэн билээ. Энэ удаа эдийн засгийн глобалчлалын хөтөч нь болсон технологийн болон улс төрийн глобалчлалын зарим гол хүчин зүйлүүдийг тогтоож, тэдгээрийн тухай тайлбарлахыг оролдлоо. Мөн түүнчлэн эдийн засгийн глобалчлалын өвөрмөц онцлогтой холбоотой, бид эдийн засгийн эрчимтэй интеграцлалын үед амьдарч байна уу, эсвэл урьд өмнө хүрсэн олон улсын эдийн засгийн харилцан хамаарлын шат руугаа явж байна уу гэсэн асуултуудад хариулахыг зорьсон юм.

Хэд хэдэн нэртэй эдийн засагчдын судалгаанаас үзэхэд өнөөгийн дэлхий нийтийг хамарсан интеграцлал нь Дэлхийн I дайны өмнө байсан гэр түвшин руу дөхөж байгаа гэнэ. Ийм интеграци анх 1913 оноос 1950 оны хооронд болж өрнөсөн бөгөөд уг интеграци нуран унаснаас хойш нэг хэсэг завсарлага авч дахин ийм интеграцийн процесс сэргэх шатандаа явж буй юм байна. АНУ-ын нэртэй эдийн засагч Паул Кругманы судалснаар 1850-1913 онд дэлхийн худалдааны экспорт дэлхийн дотоодын бүтээгдэхүүний 5-12% хувь хүртэл өссөн байна. 1950 он гэхэд дэлхийн дотоодын бүтээгдэхүүний 7 хувь хүртлээ буурчээ. 1970-аад оны эх гэхэд 12 хувь болон өсөж 1990-ээд оны эх гэхэд 17 хувь хүрсэн байна. Хэрэв дэлхийн худалдааны интеграцийн хүрсэн шинэ өндөр төвшин байгаа гэж үзвэл энэ нь зөвхөн 1970-аад оноос л эхлэлтэй ажээ. /1/ Энэхүү ерөнхий хандлага нь 1914 он хүртэлх дэлхийн эдийн засгийн интеграцийн өсөлт, Дэлхийн I дайн, Их уналт, Дэлхийн II дайн, түүний дараахи сэргэлт хөгжилт, магадгүй өнөөгийн эдийн засгийн интеграцлалын үе рүү явж буй хандлага зэрэг нь АНУ-ын хөгжлийн түүхэн замналаас тодорхой харагдаж буй аж. Тухайлбал, Дэлхийн I дайн дөнгөж дууссаны дараахан АНУ-ын экспорт, импорт нь Үндэсний Нийт Бүтээгдэхүүний 20-иос илүү хувийг эзлэж

байсан бөгөөд Их уналтын эхний жилүүдэд 8% хүртлээ унасан байна. Харин энэ хандлага дахин сэргэж улмаар 1990-ээд оны дунд гэхэд хуучин өндөр түвшинөөсөө илүү гарсан байна. /2/

Шинэ зууны гарааны эхэн үеийн худалдааны интеграцлал ерөнхийдөө Дэлхийн I дайны өмнөх хэмжээнд хүрч чадаагүй байна. Гэвч өнөөгийн олон улсын эдийн засгийн интеграци нь 1914 оны өмнөхөөс ялгаатай нь үндэстэн хоорондын интеграцлагдах чиг хандлага илүү эрчимтэй явагдаж байгаад орших аж. Үүнийг орчин үеийн худалдааны харилцааны доор хаяж 5 үндэслэл нотлон харуулж байна гэж үзэж болох юм. Үүнд:

Нэгдүгээрт, Дэлхийн худалдаанд байр сууриа эзлээгүй байсан үйлчилгээний салбар нь өнөөдөр өндөр хөгжилтэй орнуудын хамгийн хурдацтай өсөж байгаа салбар болоод байна. Саяхан хүртэл дэлхийн худалдаанд бэлэн бүтээгдэхүүн, уул уурхай болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зонхилж байлаа. Бэлэн бүтээгдэхүүний худалдаа Дэлхийн I дайны өмнөх үед ч өндөр хөгжилтэй орнууд, түүний дотор АНУ-д гол байр суурь эзлэж байжээ. Эдийн засагч Роберт Фийнстрагийн үзэж байгаагаар 1890-1913 оны хооронд Америкийн бэлэн бүтээгдэхүүний экспорт, импорт нь АНУ-ын хөдөө аж ахуй, уул уурхай, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 13-14%-ийг эзлэж байсан бол 1960 онд 10 хүрэхгүй хувь болж, нийт үйлдвэрлэлд оногдох худалдааны хэмжээ 1970 гэхэд зөвхөн Дэлхийн I дайны түвшинд хүртлээ өсчээ. Харин 1990 он гэхэд дээрх хэмжээ бараг 36 хувьд хүрсэн нь Дэлхийн I дайны өмнөх үетэй харьцуулахад бараг 3 дахин өссөн гэсэн үг юм. Их Британи, Япон зэрэг оронд нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй нь бүтээгдэхүүний худалдааны хэмжээг харьцуулбал 1990 онд 1913 оны түвшинтэй харьцуулахад доогуур байгаа аж. /3/

Хоёрдугаарт, үйлчилгээний худалдаа маш хурдан өсөж байна. АНУ-ын хувьд 1998 оны нийт экспортын 29 хувийг үйлчилгээний экспорт эзлэж байлаа. Тэгвэл 1960 онд 17 хувь, 1900 онд дөнгөж 2 хувь байсан байна. /4/ Ийнхүү глобалчлал нь зөвхөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт төдийгүй үйлчилгээний салбарт ч хүчтэй түрэн орж ирлээ.

Гуравдугаарт, өөр нэг чухал шинж тэмдэг нь эдийн засагчдын үзэж байгаагаар үйлдвэрлэл дундын худалдаа өсөн нэмэгдэж байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл, гутлыг компьютерээр солих худалдаа биш харин нэг төрлийн бүтээгдэхүүнийг хил дамнуулан худалдах явдал улам бүр өсөн нэмэгдэж байгаа явдал юм.

Дөрөвдүгээрт, үйлдвэрлэл хоорондын худалдаа нэмэгдэж байна. Бас нэг гол онцлог шинж бол нэг корпорацийн охин компаниудын хооронд буюу янз бүрийн жижиг компаниудын хооронд нэг төрлийн эцсийн бүтээгдэхүүний янз бүрийн эд ангийг өөр өөр жижиг компани үйлдвэрлэж, хоорондоо худалдах, худалдан авах явдлаар илэрч байна. Дээр дурдсан хоёр төрлийн худалдаа бол эдийн засагч Кругманы хэлснээр “эцсийн бүтээгдэхүүнийг хуваан үйлдвэрлэх” үйл ажиллагаа юм. Фирмүүд дэлхийн зах зээл дээр үйлдвэрлэх бүтээгдэхүүний эд ангийг үйлдвэрлэн бие биендээ бэлтгэн нийлүүлэгчид болон хувирч байна. /5/ Эдийн засагч Фийнстрагийн судалснаар 1972 онд АНУ-д үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 6 хувь нь импортын эд анги эзлэж байсан бол 1990 онд 14 хувь болж өссөн байна. /6/ Илүү тодорхой жишээний нэг бол 1990-ээд оны сүүлч гэхэд персонал компьютерийн 60 хувийг импортын эд анги эзлэж байв. /7/

Эцэст нь тэмдэглэхэд, глобалчлалын тухай бидний судалгаанд чухал хүчин зүйлийн нэг бол өндөр хөгжилтэй орнуудад өөрийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх болоод байгаа шинээр аж үйлдвэржсэн орнууд тухайлбал, Өмнөд Солонгос, Тайвань, Малайз, саяхнаас Хятад нэмэгдэж байгаа явдал юм. 1970 онд эдгээр орнуудаас өндөр хөгжилтэй орнуудад нийлүүлж байсан үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ өндөр хөгжилтэй орнуудын ДНБ-ий дөрөвний нэгтэй тэнцдэг байсан бол 1990 он гэхэд 1.61 хувьд хүрсэн байна. /8/ Эдгээр шинээр гарч ирж байгаа орнууд нь 1970-аад онд АНУ-ын импортоор авдаг нийт бүтээгдэхүүний 10 орчим хувийг нийлүүлдэг байсан бол 1990 оны сүүл гэхэд 22 хувь орчмыг нийлүүлж байсан явдал үүнийг гэрчилнэ. /9/

НЭГ. ХӨРӨНГИЙН УРСГАЛ: ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Орчин үед эдийн засгийн глобалчлал гүнзгийрч байгааг гэрчлэх хоёр дахь том хүчин зүйл бол хөрөнгийн зах зээлийн интеграцлал юм. Хөрөнгө нь хил дамнан янз бүрийн хүчин зүйлийн нөлөөллийн улмаас байнга шилжин хөдөлж байдаг. Фирмүүд, хувь хүмүүс богино хугацааны хөрөнгө оруулалтыг амархан борлогдох санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдах замаар хийх болжээ. Тэд гадаад орны банкинд хүүтэй данс нээх боломжтой боллоо. Мөн гадаадын компани буюу засгийн газрын гаргасан урт хугацааны бонд худалдаж авах эсвэл

гадаадын компаниудад хязгаарлалтгүй хүүтэй хөрөнгө эзэмших / компанийн нийт хувьцааны 10 хувь хүрэхгүй хэсэг/ замаар урт хугацааны хувьцаа эзэмшиж байна. Эцэст нь тэд гадаадад шууд хөрөнгө оруулах замаар гадаадын компанийг шууд хяналтандаа оруулах буюу гадаад зах зээл дээр өмчийн ихэнхи хэсгийг болон 100 хувийн хөрөнгө оруулалттай компани байгуулах бүрэн боломжтой боллоо.

1950 оноос хойш ялангуяа сүүлийн 10 жилд хөрөнгө оруулалтын гурван хэлбэр болох богино, урт хугацаатай, гадаадын шууд хөрөнгө оруулалт ихээхэн өслөө. Тухайлбал, 1998 оны дөрөвдүгээр сард нэг өдөрт маш богино хугацаатай хөрөнгө оруулалт хийхэд зориулагдсан гадаад валютын урсгал 1.5 тэрбум ам.долларт хүрсэн нь 1989 оны дөрөвдүгээр сарын нэг өдөртэй харьцуулахад 600 тэрбум ам.доллараар өссөн байна. /10/ АНУ-ын Эдийн засгийн Зөвлөхүүдийн Зөвлөлийн үзэж байгаагаар хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулах зорилготой гадаадын валютын урсгал нь эдүгээ олон улсын бүтээгдэхүүн болон үйлчилгээний худалдаанаас хол даваад байгаа ажээ. Уг Зөвлөлийн мэдээлснээр 1998 оны 4 дүгээр сарын нэг өдрийн валютын арилжаа болох 1.5 тэрбум ам.доллартай харьцуулахад 1997 оны нэг өдрийн бараа буюу үйлчилгээний экспортын хэмжээ 25 сая ам.доллар байжээ. /11/

Сүүлийн үед хөрөнгийн зах зээлийн интеграци эрчимтэй явагдаж байгаа хэдий ч урьд өмнө хүрч байсан хамгийн өндөр түвшинд арай л хүрээгүй байна. Тийм болохоор олон улсын капиталын зах зээл интеграцийн цоо шинэ шатанд гараад байна гэвэл арай эртдэх байх. Эдийн засагчид улс оронд олон улсын капиталын урсгал аль хэр чухал шаардлагатай болохыг голдуу ДНБ-д эзлэх төсвийн балансын харьцаагаар тодорхойлдог. Энэ хэмжүүрийн гол нь хэрэв тухайн улсын төсвийн баланс илүүдэлтэй байгаа бол тэрхүү орны хүмүүс гадаадын санхүүгийн хөрөнгийг худалдаж авах нь нэмэгдэх бөгөөд иймээс хөрөнгө гадагш урсах явдал ихэсдэг, хэрэв тухайн орны төсвийн баланс алдагдалтай байвал тухайн орны иргэд өөрийн хөрөнгөө гадаадынханд худалдаж эхлэх бөгөөд ийм замаар гадаадын хөрөнгө орж ирдэг байна. Хөрөнгийн орох урсгал ба гарах урсгалыг үндэсний эдийн засгийн үйл ажиллагаатай бүхэлд нь харьцуулах нь тухайн орны олон улсын капиталын зах зээл дээрхи оролцоо хэр зэрэг байгааг харуулах нэг ёсны үзүүлэлт болдог.

Энэхүү хэмжүүрийг ашиглан Маурис Обстфелдийн хийсэн тооцоогоор тухайлбал, түүний жишээ болгон сонгож авсан 12 гол орны

ДНБ-д төсвийн балансын эзлэх хувийн жин Дэлхийн I дайнаас өмнө 3.3 хувь байсан бол Их уналтын 1932-1939 онуудад 1.2 хувь болон буурсан. Тэгвэл 1990-1996 оны хооронд 2.3 хувьд хүрсэн байна. / 12/ Үүнээс үзэхэд өнөөгийн олон улсын капиталын зах зээл Дэлхийн I дайны өмнөх түвшинд хүртлээ нэг хэсэг хугацаа шаардагдах бололтой.

Хил дамнасан хөрөнгийн урсгал хөдөлгөөн эцсийн бүлэгт Америкийн эдийн засаг болон бусад орнуудын эдийн засгийн холбоо, харилцан хамаарлыг улам ойртуулж өгөв бололтой. АНУ-ын Эдийн засгийн Зөвлөхүүдийн Холбооны мэдээлснээр 1960-аад оны үед хөрөнгийн экспорт импорт \хөрөнгийн болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын аль аль нь\ АНУ-ын Үндэсний Нийт Бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцдэг байсан бол 1990 -ээд оны дундаас сүүл хүртэлх хугацаанд ҮНБ-ий 14 хувьд хүрсэн байна. \14\ Ялангуяа АНУ-ын гадаад санхүүгийн зах зээлийн оролцоонд түүний шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өсөн нэмэгдэж байгаагаараа нэлээд онцлогтой юм. 1914 оноос 1960 оны хооронд АНУ-ын гадаадад гаргасан шууд хөрөнгө оруулалт ҮНБ-ий 6-7 хувьтай тэнцэж байсан бол 1990 -ээд оны дунд гэхэд 20 хувьд хүрсэн байна. \15\ 1997 онд АНУ-ын Эдийн засгийн Зөвлөхүүдийн Холбооны мэдээлснээр “АНУ-ын үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаатай холбоотой худалдаа АНУ-ын барааны экспортын 63 хувь, импортын 40 хувийг тус тус эзлэх болсон байна.” \16\

Дүгнэж хэлбэл, өнгөрсөн 40 жилд ялангуяа сүүлийн 20 жилд үндэсний эдийн засгийн олон улсын интеграцлал худалдаа, санхүүгийн салбарт мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Хөрөнгийн зах зээлийн иймэрхүү интеграцлал Дэлхийн I дайны өмнөх үед арай хүрэхгүй байгаа мэт боловч өнөөдөр дэлхийн эдийн засгийн хөгжилтэй гол орнууд ороод байна. Түүнээс гадна олон үндэстний корпорац, хил дамнасан бие даасан нийлүүлэгчдийн сүлжээ, шинээр аж үйлдвэржсэн орнууд нэмэгдсэнээр олон үндэсний үйлдвэрлэл мэдэгдэхүйц нэмэгдэж байгаа зэрэг нь өнөөгийн олон улсын худалдааны болон олон улсын интеграцлал эрчимжин шинэ шатандаа гараад байгааг илтгэн харуулж байна.

ХОЁР. ГЛОБАЛЧЛАЛЫН ХӨДӨЛГӨГЧ ХҮЧ: ТЕХНОЛОГИ БА УЛС ТӨР

Глобалчлалын хөдөлгөгч хүч нь чухам юу вэ? Энэ асуудлыг судлаачид технологи болон улс төрийн хэд хэдэн хүчин зүйлээр авч үзжээ.

Эдийн засгийн глобалчлалын өсөн нэмэгдэж байгаа чухал бүрэлдэхүүн хэсэг бол технологи, өөрөөр хэлбэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх мэдлэг юм. Бидний үзэж байгаагаар дор хаяж 3 янзын технологийн өөрчлөлт улс орнуудын эдийн засгийг хооронд нь ойртуулж өгсөн.

Нэгдүгээрт, тээврийн технологи цаг үргэлж сайжирсан. Энэ нь бараа, үйлчилгээ, хөрөнгө, технологийн өөрийн нь ч зардлыг багасгасан. Глобалчлалын эхний шатанд тээврийн салбарт гарсан хамгийн чухал дэвшлүүд далайн тээврийн эргэн тойронд гарч байлаа. Эдгээр дэвшлийн ачаар 1870-1913 оны хооронд тээврийн зардал бараг 50 хувь орчмоор буурсан байна. \17\ Дэлхийн хоёрдугаар дайны дараахан үеэс далайн тээврийн зардал үргэлжлэн буурсан боловч 1960 оны эхэн үеэс тогтворжсон байна. Гэвч агаарын тээврийн салбарт гарсан ихээхэн дэвшлийн ачаар энэ төрлийн тээврийн зардал 1950-иад оны дундаас 1990-ээд оны сүүл хүртэл 80 орчим хувиар буурчээ. Үүний үр дүнд 1974 онд АНУ-ын нийт импортын 9 орчим хувь нь агаарын тээврээр ирдэг байсан бол 1996 онд 19 хувь болон өссөн байна. \18\

Хоёрдугаарт, худалдаа болон санхүүгийн үйл ажиллагаанд шинэ боломжийг нээсэн зүйл бол холбоо болон компьютерийн технологийн хөгжил юм. Тухайлбал, 1930 онд 3 минут ярихад 293 ам.доллар төлдөг байсан бол 1998 онд 36 цент орчим болсон./19/ Компьютерийн хүчин чадал нэмэгдэх тусам үнэ нь улам бүр буурсаар байна.

Гуравдугаарт, Фирмүүд дэлхийн эдийн засагт илүү идэвхитэй оролцохын тулд ажил үйлчилгээндээ орчин үеийн дэвшилтэд аргыг тээвэр, холбоо болон компьютерийн технологийг ашиглаж сурч байна. Олон үндэстний компаниуд хямд телехолбоо, илүү хүчин чадалтай компьютер, программ хангамж сүүлийн арван жилд интернет хэрэглэх болж үндэстэн хооронд төдийгүй тивийн хооронд өөрсдийн охин компаниуд болон бие даасан нийлүүлэгчдийнхээ хооронд үйл ажиллагаагаа зохицуулж байна. Түүнээс гадна санхүүгийн компаниуд шинэ телехолбоо, компьютерийн технологи ашиглаж валют зэрэг олон улсын санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийн худалдаа хийх болсноор барахгүй гадаад зах зээл дээрхи шинэ илүү ашигтай хөрөнгө оруулалтын боломжийг олох зэрэгт ашиглаж байна. Ийнхүү нэг талаас холбоо харилцааны хөгжил, компьютерийн технологи нөгөө талаас удирдлага болон хөрөнгө оруулалтын мэдлэгийн хөгжил зэргийн

харилцан үйлчлэл нь орчин үеийн глобалчлалын хамгийн чухал хөдөлгөгч хүчин зүйл болж байна./20/

Сүүлийн хэдэн арван жилд гарсан технологийн дэвшил олон улсын эдийн засгийн интеграцлал гүнзгийрэхэд шинэ шинэ боломжуудыг нээж өглөө. Гэвч глобалчлалыг судлагч зарим эрдэмтэд эдгээр технологийн дэвшил нь дан ганцаараа глобалчлал руу хөтлөгч хүчин болж чадахгүй, учир нь дотоодын болон олон улсын улс төрийн уур амьсгал олон улсын эдийн засгийн харилцан хамааралд таатай нөхцөл бүрдүүлсэн нөхцөлд л глобалчлал жинхэнэ утгаараа урагш явах боломжтой болно гэж үзэж байна. Тухайлбал, Паул Кругман глобалчлалын тухай өгүүлэлдээ технологийн талыг нь голчлон ярьж байгаа бөгөөд түүний нэгэн адил нэг хэсэг эрдэмтэд улс төрийн хүчин зүйлийг дурдаад 1950 оноос хойш дэлхийн худалдаанд улс төрийн хүчин зүйл гол магадгүй давамгайлах үүрэг гүйцэтгэж ирснийг тэмдэглэсэн байна./21/

Бидний үзэж байгаагаар эдийн засгийн глобалчлалын үндсийг дор хаяж улс төрийн дөрвөн нөхцөл хамтдаа бүрдүүлж байна гэж үзнэ.

Нэгдүгээрт, ндэсний засгийн газар худалдааны тариф, бусад хориг арга хэмжээг багасгах үүднээс олон талын арга хэмжээ авсан. Тухайлбал, ГАТТ-ын хүрээнд явагдсан олон талын хэд хэдэн үе шаттай хэлэлцээ, ДХБ-ын хэлэлцээрүүдийн үр дүнд өндөр хөгжилтэй орнуудын үйлдвэрийн бүтээгдэхүүндээ оногдуулж байсан дундаж тариф 40-4% хүртлээ буурсан байна. Сүүлийн жилүүдэд өндөр хөгжилтэй орнууд, шинээр аж үйлдвэржсэн орнууд, хуучин социалист орнууд, шилжилтийн эдийн засагтай орнууд бүгд хөрөнгийн хяналтаасаа татгалзаж, хөрөнгийн хил дамнасан урсгалд саад тотгор тавихаа нэгэнт болиод байна./22/.

Хоёрдугаарт, Худалдааны маргаан болон санхүүгийн хямрал гарсан тохиолдолд засгийн газрууд ГАТТ/ДХБ, ОУВС, Долоогийн Бүлэг зэргээр дамжуулан дээрх асуудлуудыг зохицуулж байна. Эдгээр хүчин зүйлүүд нь эдийн засгийн интеграцчлах үйл явцыг сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлж, дэлхий илүү нээлттэй эдийн засаг руу явах ерөнхий хандлагад эерэг хувь нэмэр оруулж байгаа юм.

Гуравдугаарт, Өндөр хөгжилтэй орнуудын засгийн газрууд дэлхийн чөлөөт эдийн засгийг бүрдүүлэхэд тэргүүлэх үүргийг гүйцэтгэхийн хамт тэд худалдаа, санхүүгийн интеграцчлалын эхлэлийг тавих үүднээс түүнд тус дөхөм үзүүлэх олон улсын гэрээ хэлэлцээрийн

систем бүрдүүлж, чөлөөт эдийн засгийн систем бүрдүүлэх явцад хувь хүмүүс болон нийгмийн хэсэг бүлэгт үүсэж болох эдийн засгийн эрсдэлийг хязгаарлах үүднээс нийгмийн даатгалын үндэсний систем бүрдүүлж өглөө. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойшхи өндөр хөгжилтэй гол гол орнуудын зүгээс явуулж ирсэн дээрх гадаад болон дотоод бодлогын уялдаа холбоог хангаж, дотоодын нийгмийн даатгалын системтэй нягт уялдуулан чиглүүлсэн энэхүү либералчлалыг Жон Ругие “шигтгэсэн либерализм”-ын эвлэрэл гэж нэрлэсэн байдаг. Энэхүү үйл явцын гол цөм нь үндэсний засгийн газар гадаад эдийн засгийн либералчлалын төлөө улс төрийн үүрэг хүлээхийн зэрэгцээ энэхүү либералчлах үйл явцад нийгмийн зарим давхаргад үүссэн сөрөг үр дагаврыг нөхөх нь засгийн газрын үүрэг болж байгаагаар тайлбарлагдана./23/

Дөрөвдүгээрт, Дээр дурдсан “шигтгэсэн либерализм” нь өндөр хөгжилтэй орнууд мөн түүнчлэн дэлхийн эдийн засгийн интеграцчлалын улс төрийн үндэс суурь болж өгсөн юм. Ийм либералчлалыг хэрэгжүүлэхийн төлөө олон улсын болон үндэсний үүрэг хариуцлагыг тогтооход АНУ-ын улс төр, цэргийн хүч гол үүрэг гүйцэтгэсэн юм. АНУ, ГАТТ/ДХБ болон ОУВС зохион байгуулах үндэс суурийг тавьж, зарим орнуудын дотоодын систем, либералчлах үйл явцад гарсан зарим зөрчил мөргөлдөөнийг зохицуулж, чөлөөт эдийн засгийн суурийг бэхжүүлэхэд үлэмж их үүрэг роль гүйцэтгэсэн билээ./24/

Бидний дээр авч үзсэн дэлхийн эдийн засгийн глобалчлалын хөгжлийн хандлагаас дор хаяж дараахи хоёр дүгнэлт хийж болох байна.

Нэгдүгээрт, Дэлхийн I дайнаас өмнөх глобалчлалыг өнөөгийн глобалчлалын түвшин, шинж тэмдэгтэй харьцуулахад Дэлхийн II дайнаас хойш олон улсын эдийн засгийн интеграцчлал эрчимжсэн гэхэд хэн ч эргэлзэх хэрэггүй.

Хоёрдугаарт, Өнөөгийн глобалчлалын ерөнхий түвшин Дэлхийн I дайны өмнөх үеийн түвшинд магадгүй хүрээгүй байж болох юм. Гэвч олон чухал шинж чанартайгаараа онцлог юм. Үүнд, олон үндэстний үйлдвэрлэл, дэлхий дахинд буй болгоод байгаа үйлдвэрлэлийн сүлжээ, олон үндэстний бие даасан үйлдвэрлэгчид, өөрийн гэсэн харьцангуй давуу талтай шинээр аж үйлдвэржсэн орнууд гарч ирээд байгаа зэргийг дурдаж болох юм. Энэ бүхэн нь глобалчлалын эхний үед хүрээгүй гэж үзлээ ч өнөөгийн эдийн засгийн

глобалчлалтай холбогдон олон улсын харилцан хамаарал ихээхэн эрчимжиж байгааг харуулж байна.

ГУРАВ. ГЛОБАЛЧЛАЛЫН ҮР ДАГАВАР

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн глобалчлалыг судлаач эрдэмтэд эдийн засгийн глобалчлалын болзошгүй үр дагаврыг 4 хэсэг хувааж авч үзсэн байдаг.

1. Эдийн засгийн глобалчлал: Олон улсын харилцан хамаарал, дэлхийн энх тайван

Томас Фредман “Мөргөлдөөнөөс сэргийлэх алтан нумын онол”-ыг дэвшүүлсэн юм. Фредманы ажигласнаар МакДональд ресторан ажиллуулдаг аль ч хоёр орон хоорондоо дайтдаггүй. Тийнхүү дайсагналцах сонирхол ч байхгүй юм байна. Тэрээр энэхүү хошин ажиглалт хийснээр “Өнөөгийн глобалчлалын систем нь улс орнууд өөрийн зорилго, ашиг сонирхолдоо хүрэхийн тулд дайн хийх нь тэдгээрийн эрх ашигт нийцэхгүй үрлэг гарлагыг нь улам нэмэгдүүлэх юм” гэсэн чухал таамаглал дэвшүүлсэн байна./25/ Фредман өнөөгийн эдийн засгийн глобалчлал нь дайны эрсдэлийг бүрмөсөн арилгана гэдэгт бүрэн итгэхгүй байгаа бөгөөд олон улсын эдийн засгийн интеграцлал дайны аюулаас сэргийлэх болно хэмээн үзэж байсан эрдэмтдийн таамаглалыг буруу гэж үзжээ. Түүний үзэж байгаагаар “өмнөх глобалчлалын үед улс орнууд асуудлаа шийдвэрлэх үүднээс дайтах асуудлыг доор хаяж хоёр удаа боддог байсан бол өнөөгийн глобалчлалын эринд тэд гурван удаа бодох болоод байгаа” ажээ./26/ Энэ бүхэн бодит эерэг үр дагаврын жишээ юм.

Үүнээс үзвэл эдийн засгийн глобалчлалын нэг боломжийн үр дагавар бол дайны аюулыг багасгаж байгаад оршиж байна. Энэхүү таамаглалыг нотлох эхний аргумент гэвэл хоёр орны хооронд эдийн засгийн харилцан хамаарал нэмэгдэх тусам орон бүр өөр өөрийнхөө амьжиргаагаа сайжруулах боломжтой болж, өөрийн түнштэйгээ харилцаагаа идэвхжүүлэх тэр хэмжээгээр хөгжих явдал юм байна. Хоёр дахь аргумент нь дайн хийх нь тэдгээрийн харилцан ашигтай, үр дүнтэй эдийн засгийн харилцааг нь бусниулах тул цэргийн мөргөлдөөнд хүргэж болзошгүй улс төр, дипломатын аливаа маргаан дэгдээхгүй байх сонирхол нь нэмэгдсээр байдагт оршино.

Дүгнэж хэлбэл, хоёр орны хооронд эдийн засгийн харилцан хамаарал нэмэгдэх тусам эдгээр улс орнуудын өөр хоорондын

маргаантай асуудлыг дайнд хүргэхгүйгээр шийдвэрлэх сонирхол нь нэмэгддэг тул эдийн засгийн глобалчлалыг эрчимжүүлэх тэр хэмжээгээр дайны аюул багасах магадлал өндөр болдог гэж үзэж болох юм.

Гэвч дээрх үзлээс өөр ч үзэл бас байна. Энэ үзлээр бол эдийн засгийн харилцан хамаарал нэмэгдэх тэр хэмжээгээр улс орнуудын харилцах цэг нэмэгдэж санал зөрөлдөх магадлал тэр хэмжээгээр нэмэгддэг гэж үздэг. /27/ Түүнээс гадна улс орон олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох тэр хэмжээгээр түргэн хөгжих боломжтой болохын зэрэгцээ тухайн орон өөрийн цэрэг зэвсэглэлийнхээ хүчийг нэмэгдүүлэхэд ч бас нөлөөлдөг байна. Иймээс олон улсын харилцаанд идэвхтэй оролцсоноор улс орнууд өөрийн хүч чадлаа нэмэгдүүлж, маргаантай асуудлыг цэргийн хүчээр шийдэх итгэл олж авдаг байна. /Барбиери, 2000 ISA presentation/. Ийнхүү энэ хоёр дахь үзэл бодлоор бол орчин үеийн эдийн засгийн глобалчлал нь дайны эрсдлийг багасгах биш харин нэмэгдүүлж буй аж.

Гуравдахь үзэл бодол бол өсөн нэмэгдэж байгаа эдийн засгийн харилцан хамаарал нь ардчилсан орнуудын хооронд тэртээ тэргүй бараг байхгүй шахам өндөр магадлалтай болсон дайны эрсдлийг улам багасгах, харин ардчилсан бус дэглэмүүдийн хооронд буюу ардчилсан дэглэм болон захиргаадалтын дэглэмийн хоорондын дайны эрсдлийг улам нэмэгдүүлнэ гэж үздэгтэй холбоотой юм./28/ Энэхүү үзэл бодлын дагуу бол засгийн газрууд глобалчлал, харилцан хамаарал гэсэн хоёр хүчин зүйлийн нөлөөнөөс үүдэн гарах эдийн засгийн өгөөжийг хүртэх гэсэн ард түмнийхээ хүсэл эрмэлзлэлийг харгалзан үзэх бөгөөд хэрэв уг ашиг сонирхол нь гадаад оронтой дайсагналцсаны улмаас хохирохоор бол ард түмнийхээ ашиг сонирхолыг засгийн газрууд эргэж бодох болно гэсэн үг юм. Ийнхүү ард түмнийхээ эрх ашгийг харгалзах, түүнд захирагдах явдал нь ардчилсан төртэй орнуудын хувьд байж болох боловч авторитар дэглэмтэй орнуудын хувьд хэрэгжих зүйл огтхон ч биш юм. Үнэн хэрэгтээ авторитар улс гүрнүүд нь ардчилсан засгийн газрууд эдийн засгийн харилцан хамаарлаас олж байгаа эдийн засгийн өгөөжөө алдахаас айж буулт хийх болно хэмээн энэхүү бодол дээрээ дөрөөлж тэднээр буулт хийлгэх бодлого явуулдаг байна. Паул Папаиоаноу-гийн судалснаар яг энэ байдал Дэлхийн I дайны өмнө авторитар Герман, ардчилсан Англи хоёрын хооронд үүссэн байна. Папаиоаноу-гийн хийсэн судалгаагаар Германы улс төрийн бүлгийнхэн Английн засгийн газар Герман-Английн худалдааг зогсоох сонирхол байхгүй хэмээн үзсэний улмаас Английн холбоотон Франц, Бельгийн

эсрэг Германы довтолгооныг эрс эсэргүүцэж чадахгүй хэмээн тооцжээ. Иймээс 1900 оны эхэн үеийн өсөн нэмэгдэж байсан эдийн засгийн харилцан хамаарал нь Герман, Англи болон түүний холбоотнуудын эсрэг илүү дайсагнасан байдалд хүргэсэн байна. /29/

2. Харилцан хамаарал: Үүсэн буй болж байгаа санхүүгийн хямрал, түүний тархалт

Одоо глобалчлал нь улс орны дотоодод хэрхэн нөлөөлдөгт анхаарлаа хандуулья. Ихээхэн ерөнхийлөн авч үзвэл эдийн засгийн глобалчлал нь улс орны эдийн засаг, нийгэм тэр бүү хэл магадгүй соёлд ч үзүүлж буй шинэ, гүн гүнзгий өөрчлөлтийн эх үүсвэр болж байна. Эдийн засгийн глобалчлалын нэг чухал үр дагавар гэвэл түүний нөлөөнд хүчтэй автагдсан олон хувь хүмүүс, үндэсний хэсэг бүлгүүд ч глобалчлалыг удирдан чиглүүлэхэд оролцох нь бүү хэл түүнийг ойлгож чадахгүйгээс үүдэн санаа их зовж байна. Энэхүү байдлыг Томас Фредман тодорхойлохдоо “Глобалчлалын үед хүмүүсийн сэтгэл санааг зовоож байгаа асуудал бол үл үзэгдэгч, барьж мэдэрч болохгүй дайсны зүгээс түргэн өөрчлөлт хийж байгаа болон эдийн засаг, технологийн нэр нь үл мэдэгдэх боловч тогтвортой үйлчлэл таны ажил, хамт олон буюу ажлын газрыг чинь нэг л мэдэхэд өөрчлөөд хаячихдаг нь глобалчлалын далд хүчин зүйлийн нэг гэж хэлж болох юм”. /30/

Асар хурдан өсөн өргөжиж хүчээ авч буй эдийн засгийн глобалчлал нь нэг л мэдэхэд эдийн засагт хүнд цохилт бэрхшээлийг авч ирэх болно гэсэн битүү хардалт, айдас их байна. Ийм байдал олон улсын санхүүгийн салбарт түүний дотор богино хугацаатай хөрөнгийн хөдөлгөөн, санхүүгийн хямрал түүний тархалт зэрэгтэй уялдан, ялангуяа шинээр үйлдвэржсэн орнуудад нэлээд тархсан байна. Үүнийг 1990-ээд оны санхүүгийн хямралын халдварын хэд хэдэн жишээ харууллаа. Заавал шинээр аж үйлдвэржсэн орон байх нь албагүй нэг буюу хэд хэдэн орнуудад гадаадын богино хугацааны хөрөнгө их хэмжээгээр орж ирснийхээ дараа гэнэт хөрөнгө эргэн гарах, тухайн орны дотоод эдийн засгийн бодлого буюу бизнесийн нөхцөл байдлаас үүдэн хөрөнгө оруулагчдын бодол өөрчлөгдөх зэргээс үүдэн тухайн орны валютын ханш унах тохиолдол гардаг. Мөн бусад орнуудад ч тэдгээрийн бодлого үйл адил төстэй буюу өөр байсан ч мөн дээрх байдал гарч байгаа тохиолдол өнөөгийн практикт олонтаа гарч байна. /31/

Санхүүгийн хямрал халдварын жишээний нэг бол 1994-1995 онд болсон Мексикийн песогийн ханшны уналт юм. Мексик төдийгүй Латин Америкийн хэд хэдэн орнуудад гадаадын хөрөнгө оруулалт багасч, энэ бүс нутгийн эдийн засаг ихээхэн сааралд орсон билээ. Тухайлбал, 1995 онд Аргентиний дотоодын нийт бүтээгдэхүүн 5 хувиар буурсан байна. (Одоо Аргентины байдал түүнээс ч дордоод байна.) Гэвч дээр дурдсанаас илүү далайцтай, удаан хугацаанд олон оронд тархсан санхүүгийн хямрал 1997-1999 онд болсон билээ. Тайландын гадаад валют хөрөнгийн зах зээлийн уналт нь 1997 оны долдугаар сард валютынхаа ханшыг албан ёсоор бууруулахад хүргэсэн юм. Мөн хямралын байдал Индонез, Малайз, Филиппин, Сингапур, Тайванийг хамарлаа. 1997 он аравдугаар сард Гонконг халдвар авч, 1997-1998 оны өвөл БНСУ хямралд оров. Зүүн болон Зүүн Өмнөд Азийн орнуудад орж байсан гадаадын зээл хумигдаж мөн тэдгээр орнууд өөрсдийн мөнгөн тэмдэгтээ хамгаалахын тулд хүүгийнхээ хэмжээг өсгөсөн зэргээс үүдэн тэдгээрийн эдийн засгийн өсөлт буурч тэр хэмжээгээр гадаадаас авдаг байсан түүхий эдийн эрэлт хэрэгцээ буурсан юм. Энэ бүхний үр дүнд нефть экспортлогч гол орны нэг болох ОХУ нь валютын спекуляцийн гол бай болж 1998 оны наймдугаар сарын дунд гэхэд рублийн ханш унаж, Оросын засгийн газар богино хугацааны дотоод, гадаад өрөө төлж чадахгүй болсноо зарласан юм. Энэ үйл явдал нь Оросыг бодвол арай оновчтой эдийн засгийн бодлого явуулж байсан Латин Америкийн орнуудыг оролцуулан бусад шинээр зах зээлийн эдийн засагт шилжиж буй орнууд хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг алдагдуулахад хүргэсэн юм. 1999 оны нэгдүгээр сар гэхэд Бразилийн засгийн газар бүс чангалах хөтөлбөр мөрдөж, валютын ханшаа албан ёсоор бууруулав./32/

Ийнхүү 1997-1999 онуудад хэдэн жил дараалан гадаадын хөрөнгийг өөртөө татаж, эдийн засгийн өсөлтийн хурдаа авч байсан шинээр зах зээлийн эдийн засагт шилжиж буй орнууд гадаадын хөрөнгө оруулалтын боломж нөхцлөө алдаж, валютын хямралд өртсний улмаас эдийн засгийн өсөлт нь саарав. Энэ бүхний уршгаар эдгээр орнуудын нийгэм эдийн засгийн асуудал нь улам хүндрэв. Тухайлбал, Мексикийн санхүүгийн хямралын уршгаар Аргентины ажилгүйдэл 1994 онд 11 хувь байснаа 1995, 1996 онд 18 хувь болтлоо өссөн байна. Өмнөд Солонгост ажилгүйдэл 1995, 1996 онд 3 хүрэхгүй хувь байснаа 1998, 1999 онд 6 гаруй хувьд хүрсэн юм. Индонезид ядуурлын хэмжээ 1997 онд 11 хувь байснаа 1998 онд 20 гаруй хувь болтлоо өсчээ. /

33/ Одоогийн байдлаар Аргентины эдийн засгийн хямрал уналт нь дэлхий нийтийн чихийг дэлдийлгэж байна.

Ази, Оросыг хамарсан санхүүгийн хямрал зөвхөн шинээр гарч ирж байсан зах зээлийн эдийн засагтай /Монгол ч орно/ орнуудаар хязгаарлагдаагүй юм. 1998 онд ийнхүү шинээр гарч ирсэн зах зээлийн эдийн засагтай орнууд хөрөнгө оруулагчдын итгэлийг алдаж эхлэхэд олон улсын хөрөнгө оруулагчид зөвхөн найдвартай гэсэн орнуудад гол анхаарлаа хандуулах болсон юм. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагчид төлбөрийн чадвартай Герман, АНУ-ын засгийн газрын гаргасан бонд зэрэгт илүү анхаарч эхэлсэн байна. Энэ бүхний үр дүнд Урт Хугацааны Капитал Менежмент хэмээх Хедж Фондын хувьд ихээхэн хөрөнгийн алдагдал амссан байна. Түүний нийт хөрөнгө 1998 оны наймдугаар сарын эхэнд 4.1 тэрбум ам.доллар байсан бол мөн оны есдүгээр сарын сүүл гэхэд 600 сая орчим болж буурсан байна. Энэ байдал буй болсон гол шалтгаан бол Урт Хугацааны Капитал Менежментэд хөрөнгөө оруулсан АНУ, Европын хэд хэдэн банкууд шинээр зах зээлийн эдийн засагт шилжиж буй орнуудад оруулаад алдсан хөрөнгийн асуудалтай холбогдон дээрх банкууд дотоод болон гадаадад зээл олгох явдлаа эрс хязгаарлаж түүний уршгаар санхүүгийн зах зээл хумигдах явдал шинээр зах зээлд шилжиж буй орнуудаас хөгжингүй орнуудын хөрөнгийн зах зээлд халдварлаж эхэлсэн байна./34/

Түүнчлэн АНУ-ын саяхны санхүүгийн хямрал, дампуурлаас болж хөрөнгийн биржүүд нь асар их алдагдал хүлээж, дампуурлын ирмэгт тулаад байна.

Зах зээлийн хомсдлын эсрэг арга хэмжээ авах мөн түүнчлэн дэлхийн санхүүгийн зах зээлийг болзошгүй нэмэлт шокноос хамгаалах үүднээс Нью Йоркийн Холбооны Нөөцийн Банк Хедж Фондын нэг болох Урт Хугацааны Капитал Менежментийг аврах санхүүгийн арга хэмжээг 1999 оны есдүгээр сарын 18-наас зохион байгуулж, АНУ-ын томоохон 14 банк, бусад санхүүгийн байгууллагууд 3.5 тэрбум ам.долларын шинэ хөрөнгө оруулалтыг хийсэн байна./35/

Хямралын дараахан АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн тэргүүн Алан Грийнспан Ази болон Оросыг хамарсан санхүүгийн хямралтай холбогдуулан хэлэхдээ Урт Хугацааны Капитал Менежментийг аврах үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай байсан хэмээн тэмдэглэсэн байдаг. Тэрээр хэлэхдээ “Сүүлийн үед дэлхийг хамарсан үйл явдлаас үзэхэд санхүүгийн зах зээлд оролцогч этгээдүүд өдий хүртэл тайвшраагүй байгаа бөгөөд “Урт Хугацааны Капитал

Менежментийн үйл ажиллагаа амжилтгүй болсон явдал хямрал бусад зах зээл рүү халдварлаж, зарим шууд хамааралгүй зах зээлийг ч хамрах аюул нүүрлэж, олон орны эдийн засагт түүний дотор АНУ-ын эдийн засагт ч сөрөг нөлөө үзүүлж байгаа билээ.” /36/

Гэсэн хэдий ч Холбооны Нөөцийн Сан дээрх аюулыг зайлуулж чадсан бөгөөд харин олон арван сургамжийн дотроос сурах ёстой сургамжийн нэг бол санхүүгийн хямрал нь магадгүй АНУ-аас алс хол оронд боллоо ч гэсэн хэзээ нэг цагт АНУ-д эргээд нүүрлэж болохыг АНУ-ын одоогийн санхүүгийн хямрал нь нотлон харууллаа. Энэ сургамж их бага бүх улс гүрэнд хамаатай.

1990-ээд оны сүүл гэхэд шинээр аж үйлдвэржсэн ихэнх орнууд санхүүгийн хүчтэй хямралд автсан боловч тэдгээрийн эдийн засаг дахин сэргэж эхлээд байна. Харин Урт Хугацааны Капитал Менежменттэй холбоотой арга хэмжээний үрээр АНУ-ын эдийн засаг тийм хүндрэл тухайн үедээ амсаагүй юм. Гэлээ гэсэн дээрхи орнуудын эрдэмтэн судлаачид болон хөгжлийн асуудлыг судалдаг олон эрдэмтдийн сэтгэлд санхүүгийн глобалчлал ямар нэг хэмжээгээр санаа зовоосон зүйл үлдээж чадсан юм. Томас Фредманы хэлснээр гол асуудал бол дэлхий дээрхи зохицуулалтгүй, хянаж болмооргүй “электрон мал сүргийг” хариулах ёстой гадаадын хөрөнгө оруулагчид гэнэт эрүүл аргаар хөгжиж буй болон шинээр үйлдвэржиж байгаа орнуудын эсрэг тэдгээрийн бодлогоос үл хамааран зөвхөн хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлоос үүдэн тухайн орнуудын эдийн засгийг уналтад хүргэж болзошгүй болоод байгаад асуудлын гол нь оршиж буй аж. Түүнээс гадна Тайланд, Индонез, Өмнөд Солонгос болон Бразилийн ард иргэд, засаг төр нь гадаадын хөрөнгийн урсгалыг сэргээхийн тулд тухайлбал, гадаадын тусламжийг ОУВС-гийн зээлийн хэлбэрээр авч хичнээн хурдан арга хэмжээ авч, дотооддоо эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтийг хийлээ ч гэсэн тэд гадаадын хөрөнгө оруулагчдын шахалт дарамтын улмаас ихээхэн хүчтэй шоконд орсон байна. Ийнхүү тэд дангаараа юу ч хийж чадахгүй гэдгийгээ гүнзгий мэдэрсэн байна. Монгол Улс ч үүний нэг тод жишээ болоод байна гэхэд бараг хилсдүүлэг болохгүй биз ээ.

3. Эдийн засгийн глобалчлал: Хөгжингүй орнуудад түлгарч буй шинэ бэрхшээлүүд

Сүүлийн 20 жилийн үйл явдал, мөн дээр дурдсан хүчин зүйлсээс үзэхэд Латин Америк, Зүүн Ази, Евроазийн шинээр үйлдвэржиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнууд санхүү,

мөнгөний хямрал, түүний халдварлалтын эрсдэлийг дэлхийн санхүүгийн глобалчлалтай холбогдон амсаж эхлээд байна. Хөгжингүй орнууд ч мөн глобалчлалын хүчин зүйлийн нөлөөллөөр шинэ асуудлуудтай тулгараад байгааг бид харж байна. Ялангуяа худалдааны глобалчлал болон үндэстэн дамнасан корпораци, олон үндэстний үйлдвэрлэлийн сүлжээ өсөн нэмэгдэж байгаатай холбогдсон олон шинэ асуудал тулгарч байна.

Хөгжингүй орнуудын хувьд худалдаа, санхүүгийн интеграц нь худалдааг хөгжүүлэхэд нөлөөлж, эдгээр орнуудын ард түмний амьдралд эерэгээр нөлөөлж байгаа нь эргэлзээгүй боловч энэ нь нөгөө талаар глобалчлалын давуу талыг нэг хэсэг хүмүүс ашиглаж, баян ядуугийн ялгаа нэмэгдэж байгаа явдал юм. /Ялангуяа нэг талаас мэргэжилтэй ажилчид ба хөрөнгийн эзэд нөгөө талаас мэргэжилгүй ажилчид хоёрын амжиргааны ялгаа өсөн нэмэгдэж байна/ Түүнээс гадна глобалчлал нь тухайн орнуудын засгийн газрын үүрэг ролийг хязгаарлаж, баян ядуугийн ялгааг багасгах чиглэлээр засгийн газрын зүгээс ямар нэг ажил хийх чадваргүй болгож байгаа явдал юм. Тэр ч бүү хэл глобалчлал нь зөвхөн ашиг орлогын ялгааг арилгахад чиглэсэн засгийн газрын үүрэг бүү хэл өөрийн орны нийгмийн тодорхой давхаргын ажлын нөхцлийг сайжруулах буюу байгаль орчны цэвэр байдлыг хадгалах зэрэгт чиглэсэн арга хэмжээгээ ч зарим тохиолдолд авч чадахгүйд хүргэж байна.

Глобалчлал нь хөгжингүй орнуудын нийгэмд хоёр төрлийн нөлөө үзүүлж байна гэж болохоор байна. Нэг талаас, АНУ болон зарим талаар Их Британид ажилтай хүмүүсийн хувийн жин их байгаа хэдий ч орлогын ялгаа ихсэж байна. Нөгөө талаас, Баруун Европын орнуудад ажилгүйдэл их байгаа хэдий ч орлогын ялгаа ихээхэн бага байгаа явдал юм./37/ Америкийн эдийн засаг глобалчлагдаад байсан 1970-аад оны эхнээс 1990 оны эх хүртэлх хугацаанд Америкийн дээд сургууль төгсөөгүй ажилчдын бодит цалингийн хэмжээ бараг 25 хувиар буурсан, 1970-1992 онд бага цалинтай ажилчдыг илүү их цалин авдаг хүмүүстэй харьцуулахад мөн 25 хувиар өссөн байна./38/ 1990-ээд оны сүүл гэхэд дээр дурдсан хугацааны хооронд АНУ-д ажилгүйдэл 4 орчим хувиар буурсан бөгөөд Баруун Европод ажилгүйдэл 10 хувиас ер буураагүй байна./39/

Худалдааг чөлөөтэй болгох асуудлыг шүүмжлэгчдийн үзэж байгаагаар ялангуяа Мексик, Хятад, Тайланд мэтийн цалин багатай орнуудтай худалдаа хийхэд аж үйлдвэржсэн орнуудад ажиллах хүчний

эрэлт хэрэгцээ эрс буурахад шууд нөлөөлж байна. Тэдний үзэж байгаагаар ажиллах хүчний асуудлаархи Столпер-Самуэлсоны теоремийн дагуу худалдаа нь цалин болон хөдөлмөрийн нөхцлийг засгийн газрын зүгээс бага хянадагтай уялдан АНУ-д орлогын тэнцвэргүй байдлыг бүрдүүлж, боловсролгүй ажиллах хүчний эрэлт хэрэгцээг багасгаж, ажилгүйдлийг нэмэгдүүлж байгаа төдийгүй ажилчдын цалинг бууруулахад хүчтэй нөлөөлж байна. Харин Европын орнуудад худалдааны нөлөөгөөр боловсролгүй ажиллах хүчний эрэлт хэрэгцээ буурсан явдал нь ажилгүйчүүдийн тоог нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна. Учир нь Европын орнуудын засгийн газрууд ажилчдын хөдөлмөрийн хөлсийг тодорхой түвшинд тогтоож, ажилчдыг халах явдалд хязгаарлалт тогтоосон байдаг тул ажиллах хүчний эрэлт хэрэгцээ буурах явдал нь цалинг бууруулахад бус харин шинээр ажиллах хүчин авах хэрэгцээг хязгаарлахад нөлөөлсөн байна.

Эдийн засагчдын үзэж байгаагаар боловсролгүй ажиллах хүчний эрэлт хэрэгцээ ерөнхийдөө буурах хандлагатай байгаа аж. Эрдэмтдийн үзэж байгаагаар сүүлийн 20 жилд ажиллах хүчний эрэлт хэрэгцээ түүнтэй холбогдон цалин буурахад худалдааны шууд нөлөөлөл 10 хувь орчим л байгаа бөгөөд хамгийн их гэхэд 20 хувиас хэтрэхгүй байгаа аж./40/ Гэвч зарим эрдэмтдийн үзэж байгаагаар худалдаагаар дамжин гадаадын өрсөлдөөн нэмэгдэж, түүний үр дүнд компаниуд технологийн шинэчлэл хийж байгаа аж. Иймээс худалдаа нь нэг талаас боловсролгүй ажиллах хүчний эрэлт хэрэгцээг бууруулж, нөгөө талаас өндөр хөгжилтэй орнуудад технологийн шинэчлэл хийхэд шууд бус нөлөө үзүүлж байна гэж үзэх үндэстэй юм./41/ Түүнээс гадна Роберт Фийнстрагийн үзэж байгаагаар өндөр хөгжилтэй орнуудад гарч буй технологийн шинэчлэл тухайлбал, холбоо харилцааны үнэ өртөг улам хурдан хямд болж байгаа зэрэг нь эдгээр орнуудад ажиллах хүчний хэрэгцээг улам бууруулж байна./42/

Мөн худалдааны интеграцлал нь боловсролгүй ажиллах хүчний хэрэгцээг дангаараа бууруулаад зогсохгүй дээрх төрлийн ажиллах хүчинд бас өөр сөрөг нөлөөлөл авч ирж байна. Дани Родрикийн тэмдэглэсэнээр ийм сөрөг нөлөөлөлийн нэг бол АНУ-ын пүүс компаниуд олон улсын зах зээлд нэвтрэх явдал хялбар болох тусам АНУ-д хөдөлмөрийн хөлсний өчүүхэн ч атугай өөрчлөлт дунд шатны боловсруулалттай бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэгчдийг өөрийн орноосоо шууд гадаад оронд шилжүүлэх шалтгаан болж болзошгүй ажээ. Тэрээр цааш өгүүлэхдээ Америкийн хар ажилчид

цалингаа нэмэгдүүлэх тусам тэдгээр ажилчдын хэрэгцээ буурахад нөлөөлөх болно хэмээн тайлбарлаж, хэрэв ажилчид цалингаа нэмэгдүүлэхийн төлөө шахалтаа нэмэгдүүлбэл тэдний байдал улам хүндрэх бөгөөд цалингийн хэлбэлзэл улам нэмэгдэх болно гэж тайлбарлажээ./43/

Ийнхүү худалдааны интеграц нэмэгдэх явдал аж үйлдвэржсэн орнуудын ажилчдын бодит орлогыг бууруулахад шууд, шууд бусаар нөлөөлж байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Гэвч глобалчлал нь түүнээс ч илүү нөлөө үзүүлэх бололтой. Глобалчлалын өргөн боломжийг ашиглахын тулд засгийн газрууд ажилчдад тулгарч буй асуудлыг зөөлрүүлэхэд чиглэсэн санхүү, мөнгө, нийгмийн бодлого явуулахад Фредманий нэрлэснээр глобалчлал өөрөө “алтан хүлээс” болж байна. Тухайлбал, хэрэв засгийн газар ажилчдын орлогыг нэмэгдүүлэх үүднээс компаниудад ноогдуулах татварыг нэмэгдүүлбэл уг компаниуд бизнесийн үйл ажиллагаагаа татвар багатай бизнес хийхэд илүү таатай орон руу шилжүүлэх болно. Үнэн хэрэгтээ засгийн газрууд зөвхөн глобалчлалын нөлөөнөөс үүдэн орлого нь буурч байгаа ажилчдын байдлыг сайжруулахын тулд бус уг компаниуд бизнесийн илүү орчин эрж, гадагш гарахаас айж, хөдөлмөрийн орчинг сайжруулахын төлөө санаа тавьж ажилладаг байна.

Иймээс зарим эрдэмтэд эдийн засгийн глобалчлал нь өндөр хөгжилтэй орнууд чөлөөт байдлыг эрхэмлэсэн бодлогоосоо татгалзахад хүргэж, ажилчид болон нийт үндэснийхээ эрх ашгийн үүднээс бодлого явуулж эхлэхэд хүргэж болзошгүй гэсэн болгоомжлолоо ч илэрхийлж байна. Өндөр хөгжилтэй орнуудын засгийн газрууд өөрийн оронд гадаадынхан орж ирэх явдлыг чөлөөтэй байлгаж, харин хариуд нь засгийн газрын дэмжлэгээр ажилчдын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн татварын бодлого явуулах хувилбар байж болох юм. Ажилчдын хувьд эрүүл мэнд, нийгмийн даатгалын зохистой систем бүрдүүлэх чиглэлээр Засгийн газрынхаа авч буй арга хэмжээний тал дээр санал нэгдмэл байдаг байна.

Харьцангуй өндөр дадлага, боловсролтой Америк, Европын ажилчид ажилгүй болж буй хүмүүс өөр өөрсдийн ажлын чадавхиа дээшлүүлэх ёстой гэсэн үзэл бодолтой хүмүүс байж болох юм. Яагаад эдийн засгийн глобалчлалын үр дүнд хожигч тал хохирогч талдаа үл хайхарсан байдлаар ханддаг нь дор хаяж дараахи хоёр шалтгаантай байна. Нэгдүгээрт, Глобалчлалын нөлөөнөөс хохирогч талууд өөрсдийн дургүйцлээ илэрхийлэх хувилбар байхгүй гэсэн үг биш юм. Тэд эдийн

засгийн үндсэрхэг үзэлтэн болж хувирах юм уу хамгийн цаад зах нь гэхэд глобалчлалыг хумих гэж оролдох явдал юм. Хоёрдугаарт, ажилчдын эцсээ хүртэл тэмцэх явдал нь шинэ глобал эдийн засгийн өнөөгийн нөхцөлд уг тэмцэгч глобалчлалаас хохирогч тал төдийгүй зарим талаар глобалчлалын нөлөөгөөр хожигч талд ч муугаар нөлөөлж амьжиргааны түвшинг нэлэнхүйдээ бууруулахад нөлөөлж болох магадлал бий. Магадгүй глобалчлал нь өнөөдөр өндөр хөгжилтэй орнуудын засгийн газрууд ажилчдад нийгэм эдийн засгийн хамгаалах механизм бүрдүүлэхэд нь саад тотгор учруулж байж болох. Харин маргаааш байгаль орчныг хамгаалах буюу бүр хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалсан бодлого явуулахад нь ч улам бүр их саад тотгор учруулж болзошгүй. Хэрэв энэ байдал үүсэх юм бол өнөөгийн эдийн засгийн глобалчлалаас хожигч болон хохирогч аль аль талд муу нөлөө үзүүлэх болно.

4. Эдийн засгийн глобалчлал: Америкийн соёл

Томас Фредман болон бусад глобалчлалын асуудлыг судлаачид дэлхийн эдийн засгийн интеграцлалд оролцож буй орнуудын өмнө тулгарч байгаа гурав дахь асуудлыг тодорхойлсон байдаг. Энэ бол нэг талаас дэлхийн эдийн засагт нэгдэн интеграцлалд орсноор хожиж буй сайн талууд нөгөө талаар хэл, бичиг, мэдээлэл зэрэг үндэснийхээ соёлыг хадгалж үлдэх асуудлын тэнцвэрийг хангах асуудал юм. Хөгжингүй, хөгжиж буй олон орнуудын өмнө тулгарч буй асуудал бол глобалчлалын нөлөөгөөр үүсэж буй шинэ соёлын үндсийг зөвхөн Америкийн соёл бүрдүүлж байгаад оршино. Фредман бичихдээ: "Глобалчлал нь Америкийн нүүр царайг бүрдүүлж байна. Энэ нь Мики Маусын чихтэй, Биг Максиг илдэг, кока кола, пепси удаг, Windows 98 программтай Intel Pentium IV процессортой IBM буюу Apple компьютер хэрэглэдэг, Casio системтэй холбогдсон. Иймээс глобалчлал, американизм хоёрын ялгаа олонхи америкчуудад ойлгомжтой байж болох боловч дэлхий дахинд олон хүнд сайн ойлгогдохгүй байгаа юм. Ихэнх нийгэмд хүмүүс нэг талаас Америкийн хүч, Америкийн экспорт, Америкийн соёлын довтолгоо, Америкийн соёлын экспорт нөгөө талаас глобалчлалын хоорондын ялгааг ойлгохгүй байна. Үнэндээ дээрх бүх зүйл нь өөр хоорондоо холилдон сүлжилджээ." /44/

Эдийн засгийн глобалчлалаар дамжуулан Америкийн соёлын нөлөө хүчтэй болж түүнээс гадна уг соёлын нөлөөний эсрэг хөгжингүй

орнууд тухайлбал, Франц Улс Америкийн киноны талаархи дургүйцлээ илэрхийлж байгаа зэргийг бид харж байгаа билээ. Америкийн кино 1990-ээд оны сүүл гэхэд Европын Холбооны Улсуудын үзэгчдийн 70-80 хувь, зөвхөн Францад гэхэд үзэгчдийн 60 орчим хувийг эзэмдсэн байна./45/ Францын засгийн газар Европ болон дэлхийн киноны зах зээл дээр АНУ-ын ноёрхол, Америкийн кино импортлохын эсрэг Францын киноны зах зээлийг өргөжүүлэхэд чиглэсэн өөрийнхөө зах зээлийг хамгаалсан нарийн бодлого явуулж эхэлсэн байна. Түүнээс гадна Франц нь Европын холбоотнуудаа Европын кино, телевизийн зах зээлийг АНУ-ын киноны давалгаа, давамгайллаас хамгаалахад чиглэсэн дэмжлэгийг авч чадсан байна.

Гэвч Франц болон түүний холбоотнуудын энэхүү бодлогыг авч үзэхээс өмнө уг бодлогын гол утгыг авч үзэх нь зүйтэй юм. АНУ кино, телевиз зэрэг соёлын салбарт давуу тал олж авсан нь түүний чанарын давуу талд бус АНУ-ын энэ салбар дахь шудрага бус бизнесийн бодлоготой холбоотой гэж Францын засгийн газар үздэг байна. Ялангуяа, Францчуудын үзэж байгаагаар дэлхийн мэдээллийн салбарт АНУ бараг монопол тогтоогоод байгаа аж. АНУ-ын кино, үзвэрийн сурталчилгааг дотооддоо төдийгүй дэлхийн зах зээл дээр өргөнөөр явуулж түүнээс олсон хөрөнгөөр энэхүү салбараа улам өргөжүүлж байдагтай холбоотой юм байна. Энэ мэтчилэн хүчин зүйлээс үүдэн АНУ-ын кино болон бусад үзвэр нь урлаг, соёл, ёс суртахууны хувьд дутагдалтай ч дэлхийн зах зээл дээр ноёрхож байгаагийн нэг шалтгаан гэж Францын улс төр, соёлын олон зүтгэлтнүүд үзэж байгаа юм.

Америкийн кино, телевизийн урлагийн эсрэг дэвшүүлдэг Францын хоёр дахь аргумент бол Америкийн кино, телевиз хичнээн амжилттай байлаа ч түүний нөлөөллөөс өөрийн хүн амаа хамгаалах эрх, үүрэгтэй гэж үздэг байна. Хоёр хүчин зүйл энэхүү үзлийн үндэс болж байна.

Нэгдүгээрт, Францын засгийн газарт ажиллаж байгаа болон түүний гадуур ажиллаж байгаа Францын соёлын элитүүд Америкийн кино, телевизийн нэвтрүүлэг мөн түүнчлэн поп хөгжим нь урлагийн хувьд үнэ цэнэ багатайгаас гадна соёл, ёс суртахууны хувьд ч дутагдалтай гэж үздэг.

Хоёрдугаарт, Америкийн дээрх соёл нь Франц иргэдийн соёл, хэлний хөгжилд алсдаа муу нөлөөтэй гэж үзэж байна. Францын Экономист сэтгүүлийн нэгэн өгүүлэлд “Өсөн нэмэгдэж буй Америкийн соёл Францын соёлыг ганхуулж байна” гэж тэмдэглэжээ. Францын

соёлын элитүүдийн хувьд гол асуудал нь чухам хэн Америкийн кино их үзэж байна гэдэгтээ бус харин “Холивууд бол Парисын диснейланд, Америкийн түргэн хоолны газар, хувцаснаас эхлэн рок хөгжим хүртэл чөлөөт сурталчилгааг авч ирж буй гурвалсан морь юм” гэж үзэж байна./46/ Иймээс энэхүү үзлийн дагуу бол Францын соёлыг хадгалахын тулд Францын засгийн газар Францын кино урлагийг дэмжих үүрэгтэй бөгөөд олон франц хүн Америкийн кино үзэх сонирхолтой байлаа ч тэр нь Франц хүмүүст шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй ч Америкийн кино, телевизийн урлагийг Францад чөлөөтэй нэвтрүүлэхгүй байх ёстой ажээ. Өөр нэг үзэл бол Америкийн соёл нь франц төдийгүй Европын соёлыг америкчлах, хэлийг бохирдуулах болно гэсэн үзэл юм.

Америкчуудын хувьд Францын дээр дурдсан үзэл бодлыг нь зөвхөн Францчууд өөрсдийн их гүрний байр сууриа алдсандаа л тэгж үзэж байгаа гэж үздэг. Гэвч Францаас тэс өөр соёлтой орнуудын зүгээс ч адил төсөөтэй шүүмжлэлийг бид сонсдог. Тухайлбал, Канадад нийт гарч буй киноны 95 орчим хувь нь гадаадынх бөгөөд түүний ихэнх нь Америкийнх байдаг ба уншдаг ихэнх сэтгүүлүүд нь гадаадынх бөгөөд дахиад л түүний ихэнх нь Америкийнх байдаг./47/ Чухамдаа иймээс л Канадад АНУ-тай эдийн засгийн хувьд ойр интеграцчлах нь өвөрмөц Канадын соёлд сөрөг нөлөөтэй хэмээн үзэж байна. Тийм учраас энэ талаархи яриа шүүмжлэл удаан үргэлжилж байгаа билээ./48/ Харин Канад нь өөрийн соёлын өвөрмөц байдлаа Америкийн эдийн засагтай ойртон нэгдсэн ч хадгалах болно гэж үздэг. Дүгнэж хэлбэл, дэлхий дахинд үндэсний соёлыг америкчилж байна гэсэн үзэл өргөн тархаж, тэр нь нэмэгдэж байгаа явдал таатай зүйл биш бөгөөд мэдээж дэлхийн эдийн засгийн глобалчлалын эрчимжиж байгаагийн салшгүй нэгэн хэсэг болж байна.

Их гүрнүүд хүртэл хэл, соёлоо хамгаалах талаар иймэрхүү чиг бодлого баримталж байхад Монголчууд бид энэ талаар одооноос анхаарч, уян хатан бодлого боловсруулах цаг болжээ.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛ: УЛС ОРНУУДЫН ҮЗЭЛ БОДОЛ, БАЙР СУУРЬ

Одоо бид эдийн засгийн глобалчлалын эринд улс орнууд шинэ нөхцөл байдалд хэрхэн дасан зохицож байгаа талаар өгүүлье. Өнөөг хүртэл улс орнууд дэлхийн эдийн засагтай нэгдэн хөл нийлүүлж

алхахдаа ихэнхдээ ганцаарчилсан байр суурь баримталж ирсэн бөгөөд энэхүү бодлого нь голдуу эдийн засгийн глобалчлалаар олгогдсон шинэ боломжийг ашиглах, шинэ нөхцөл байдалд дасан зохицох зэрэгт үндсэндээ чиглэж иржээ. Зарим тохиолдолд улс орнууд бие даан гадаад нөлөөлөлд хязгаарлалт тавих, дэлхийн эдийн засагтай улс орныхоо эдийн засгийг интеграцчлах үйл явцыг түр саатуулах зэрэг тохиолдол гарч байна. Түүнээс гадна заримдаа улс орнууд эдийн засгийн глобалчлалын үрээр буй болсон бэрхшээлийг даван туулахдаа хамтарч ажиллах тохиолдол ч байна. Энэхүү хамтран ажиллах хандлага нь дэлхийн эдийн засгийн томоохон интеграцчлалыг хязгаарлахад ихэвчлэн чиглэж байгаа юм. Гэхдээ хамтын ажиллагааны ихэнхи хэлбэрүүд глобалчлалыг хязгаарлах бус харин түүнийг улс орнуудын эрх ашигт зохицуулан хөгжүүлэхэд чиглэж байгаа нь өнөөгийн гол чиг хандлага болоод байна.

1. БИЕ ДААСАН ЧИГ ХАНДЛАГА

Ихэнх тохиолдолд улс орнууд дэлхийн эдийн засгийн интеграцчлалтай алхаа нийлүүлж түүний үр шимийг хүртэхийг хүсч байна. Хэдий тийм боловч интеграцчлах процесс нь улс орны бие даасан бодлого явуулахад нь бас зохих хэмжээний хязгаарлалт авч ирдэг тул түүнд зохицон нийцэх шаардлагатай байдаг юм. Тухайлбал, Аргентин дангаараа 1990 -ээд оны эхээр худалдаа, хөрөнгийн хөдөлгөөн зэрэгт саад тотгор тавихаа больж, өөрийн мөнгөн тэмдэгт песо-г ам.долларт уясан юм. Гэвч 1994-1995 онд Мексикээс эхэлсэн санхүүгийн хямралын үед ч энэхүү бодлогоосоо ухраагүй юм. Харин ч Аргентин эдийн засгийн өсөлт нь саарсан хэдий ч эдийн засгаа улам чөлөөтэй болгох, интеграцчлалд ороход чиглэсэн бодлогоо хэвээр үргэлжлүүлсэн./49/ Үүний үр дүнд Латин Америкдаа Америк маягийн хөгжлийн сонгодог жишээ болж байсан Аргентиний эдийн засаг өнөөдөр ангалын ирмэгт тулаад байгаа билээ. Үүний нэгэн адил глобалчлалын шаардлагад үнэнч гэдгээ Өмнөд Солонгос, Тайланд, Филиппин, зарим талаар Индонез мэтийн Азийн орнууд өөрсдийн жишээгээрээ харуулсан юм. Эдгээр орнууд санхүүгийн хямралын яг ид үе болох 1997-1998 онуудад тэд дэлхийн эдийн засгийн харилцаанаас өөрсдийгөө огтхон ч тусгаарлаагүйг бид мэднэ. Харин ч тэд дэлхийн эдийн засагт нээлттэй байж үндэсний мөнгөн тэмдэгт болон санхүүгийн системд нь итгэх олон улсын итгэл буураад байсан хүнд үед бүс чангалах мөнгө, санхүүгийн бодлого явуулах төдийхнөөр хязгаарлаагүй юм. Дээрхи орнуудын Засгийн газар үндэсний банкны системийг эрс шинэчлэх зорилт тавьж,

ОУВС-ийн хөтөлбөрийг хүлээн авч хэрэгжүүлсэн билээ. Эцэст нь хэлэхэд дэлхийн эдийн засгийн хөгжлийн шинэ шаардлагыг Европын Холбооны ихэнх орнууд ерөнхийдөө хүлээн зөвшөөрч байгааг бид бүхэн харж байна. Эдгээр орнууд 1990-ээд оны сүүлээр Эдийн засаг, Мөнгөний Нэгдсэн Холбоо байгуулснаар санхүү, мөнгөний өөрөө өөрийгөө удирдах зарчмыг нэвтрүүлж байна. Эдүгээ уян хатан хөдөлмөрийн зах нээж, Европ болон бусад орны фирмүүд хаана хөрөнгө оруулахаа сонгох боломжийг нээлттэй байлгах талаар ихээхэн ярих боллоо. Түүнчлэн Европын Холбоо энэ оны эхнээс мөнгөний нэгдсэн нэг нэгжтэй боллоо.

Ийнхүү улс орнууд өсөн нэмэгдэж байгаа эдийн засгийн глобалчлалд хандахдаа ихэнхдээ түүнд зохицох, интеграцчлах үйл явцад илүү бүрэн дүүрэн оролцоход ихээхэн анхаарч байгаа бөгөөд глобалчлалын зарим дутагдалтай талыг хүлээн зөвшөөрч, түүнийг даван туулахад чиглэсэн эдийн засаг, бизнесийн бодлого төлөвлөхөд анхаарлаа хандуулах болжээ гэж дүгнэн хэлж болох байна.

Гэвч эдийн засгийн глобалчлалын үр шимийг ихээхэн хүртэх боломжтой байсан хэдий ч түүнээс ухарсан орнууд ч цөөнгүй бий. Тухайлбал, Чили богино хугацааны капитал ихээхэн орж ирвэл сөрөг нөлөөтэй хэмээн үзэж 1991 онд капитал орж ирэхэд хяналт тавьсан юм./50/ 1997-1998 оны Азийн санхүүгийн хямралын ид үед Малайз нь өөрийн хөрш орнуудад авч байсан арга хэмжээнүүдтэй тааруулж бодлогоо өөрчилж эхэлсэн бөгөөд харин нэг л асуудлаар хөршүүдээсээ тэс өөр бодлого хэрэгжүүлсэн юм. Энэ бол 1998 оны есдүгээр сард хөрөнгийн хөдөлгөөнд яаралтай хяналт тогтоож, улс орноо олон улсын хөрөнгийн зах зээлээс тодорхой хэмжээгээр тусгаарласан./51/

Дээрхийн нэгэн адил дэлхийн эдийн засгийн харилцаанаас тодорхой хяналттайгаар ямар нэг хэмжээгээр өөрийгөө тусгаарласан орнуудын тоонд Франц, Канад орж байна. Тухайлбал эдгээр орнууд Америкийн соёлын бүтээгдэхүүн импортлохоос болгоомжилж эхэлсэн юм. Канад нь Америкийн сэтгүүл, Франц нь дуу, дүрс бичлэгийн бүтээгдэхүүн импортлохоос болгоомжилж эхэлсэн байна. Тухайлбал, Францын засгийн газар Америкийн киноны импортод квот тогтоосон явдал юм. Мөн хүүхэлдэйн киноны сувгаас бусад кабелийн нэвтрүүлгийг хориглосон. Мөн нэвтрүүлж буй дууны 40 хувь нь Франц дуу байх ёстой гэсэн шаардлага тавьсан байна. Мөн Францын засгийн газар кино театруудад гарч буй кинонд тусгай татвар ноогдуулж / 1990-ээд оны дунд үеийн байдлаар жилд дундажаар 150 сая

ам.долларын орлого оруулж байсан/ түүнээс орсон хөрөнгөөр Францын кино үйлдвэрт татаас олгож байв./52/

Дээрхийн нэгэн адилаар Канадын соёлын аюулгүй байдлыг хангах нэрийдлээр Канадын сэтгүүлийн үйлдвэрлэлийг Америкийн өрсөлдөгчдөөс нь хамгаалж байв. 1995 онд гадаадын гаралтай сэтгүүлүүдэд 80 хувь хүртэл татвар оногдуулж байв. Энэхүү өндөр татварын гол учир нь Америкийн сэтгүүлүүдээс арай хямд тусах Канадын сэтгүүлүүдэд сурталчилгаагаа хэвлэх бөгөөд Америкийн сэтгүүлийг бодвол илүү хямд Канадын сэтгүүлд Канадчууд өөрсдөө ч гэсэн сурталчилгаагаа хэвлэх болно гэсэн тооцоо юм. Энэхүү тооцоогоор бол Канадын сэтгүүлийн үйлдвэрлэл засгийн газраас дэмжлэг авах шаардлага үгүй болж, Канадын өвөрмөц соёлыг хамгаалахад хувь нэмрээ оруулах ёстой байлаа. Гэвч АНУ энэхүү татварын асуудлыг ДХБ-ын маргааныг шийдвэрлэх механизмын хүрээнд хэлэлцүүлж 1997 оны долдугаар сард АНУ ялсан юм. Канад нь маргааны зохицуулалтын дүнг зөвшөөрч татвараа ноогдуулахаа больсон боловч энэ нь Канадын бие даасан сэтгүүлийн үйлдвэрлэлийн өсөлт улмаар Канадын соёлын хөгжилд сөрөг нөлөө үзүүлсээр байгаа талаар гомдоллосон хэвээр байна./53/

АНУ-ын худалдааны бодлого боловсруулагчдын үйл ажиллагаанаас үзэхэд “глобалчлалаас залхах” байдал харагдаж байна. АНУ-ын хамтын шийдвэрүүд нь глобалчлалд түр ч атугай завсарлагаа өгөх шинжтэй байна./54/ Тухайлбал 1997 онд Чилийг НАФТА-д оруулах асуудлыг хэлэлцэх эрхийг Ерөнхийлөгчид олгохгүй байхаар АНУ-ын Конгресс шийдвэрлэсэн нь цэвэр дотоод улс төрийн хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой байв. Түүнээс гадна Конгрессээр 1993 онд НАФТА, 1994 онд ДХБ-ын асуудлыг хэлэлцэхэд Америкийн худалдааг либералчлахад улс төрийн асуудал гарч байсан юм. Түүний нэгэн адил 1998 онд хэлэлцүүлэхээр санал болгосон Хөрөнгө оруулалтын талаархи Олон талт хэлэлцээрийн талаар үйлдвэрчний болон хүрээлэн буй орчны талаархи группууд эргэлзэж байсан ба түүнийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, Хөгжлийн байгууллагын гишүүн өндөр хөгжилтэй орнуудаар хэлэлцүүлэх эцсийн шатанд АНУ-ын засгийн газар яриа хэлцээг цаашид үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн боловч тохиролцоог аажмаар амжилтгүй болгох байр суурь баримталсан юм./55/ 1999 оны сүүл 2000 оны эх гэхэд АНУ-ын Конгресс/ ялангуяа Төлөөлөгчдийн Танхим/ Африкийн орнуудын өчүүхэн хэмжээний бүтээгдэхүүнийг тэд нарт туслах үүднээс татваргүй оруулах асуудлын талаар хуулийг

батлаагүй. Мөн Дэлхийн Банкны гишүүн өндөр хөгжсөн түнш орнуудын санал болгосон өрөнд баригдсан орнуудад туслах зорилгоор хөгжингүй орнуудын татварыг бага ч атугай хөнгөвчлөх төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ АНУ-ын эрх баригчид дурамжхан хандсан юм./56/ 1990-ээд оны сүүлээр ДХБ-ын тохиролцооны хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг чөлөөтэй болгох асуудалд Европын эрх баригчид санаа зовж түүнд хойрго хандсан. Энэ нь тэд бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүйн байдалд санаа зовсондоо бус худалдаа чөлөөтэй болгох эдийн засгийн глобалчлалыг цаашид гүнзгийрүүлэх асуудалд шинэ хувь нэмэр оруулах дургүй байгаа улс төрийн тооцоо байсан юм. Ийнхүү сүүлийн үед дэлхий нийтээр либералчлах бодлогод хойрго хандах болоод байгаа нь буурай хөгжилтэй орнуудын хувьд ихээхэн анхаарал татсан асуудлын нэг болоод байна.

Эцэст нь тэмдэглэхэд их гүрнүүд ялангуяа АНУ эдийн засгийн шинэ глобалчлалын энэ үед улс орнуудын хоорондын харилцаанд янз бүрийн нөхцөл болзол тавих явдал нэлээд гаргаж байгааг бид мэдэх билээ. Тухайлбал, 1990-ээд оны эхээр АНУ нь Мексик буюу бусад гадаадын загас агнуурын пүүсүүд АНУ-ын зах зээлд нэвтрэхийг хүсвэл түүнэс загас агнах нөхцөлийг хангасан байхаар асуудлыг зохицуулсан юм. Энэхүү зохицуулалт хийх АНУ-ын гол зорилго бол гадаадын загас агнуурын компаниуд түүнэс агнах явцад тэдний торонд үрэгддэг далайн гахайг хамгаалах үүднээс тусгай тор хэрэглэх шаардлага тавьсан байна. АНУ-ын загас агнуурын хуулийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс дээрх шаардлагыг гадаадын загасчдад сахин мөрдүүлэх үүднээс авсан арга хэмжээ байсан юм./57/ Дээрх асуудлаар Мексик ГАТТ-д АНУ-ын эсрэг асуудал тавьж ялсан боловч загас агнуурын дээрх шаардлагыг хэрэгжүүлж чадсан юм. Үүний нэгэн адилаар АНУ өөрийн худалдааны түншүүдийнхээ нефтийн танкерүүдэд нефть тээвэрлэлтийн үед гадагш асгарахгүй байхаар торнуудаа тоноглох шаардлага тавьж, түүнийг хуульчлан бүртгэлд оруулсан байна./58/ Мөн АНУ өөртөө ашигтай байхаар банкны доод захын нөөцийн хэмжээг бусад орны банкуудад тогтоохыг шаардсан./59/ АНУ болон зарим Европын Холбооны гишүүн орнууд хөгжиж буй орнуудад үзүүлдэг худалдааны хөнгөлөлтийг тэдгээр орны дотоодын ажилчдын эрх хөдөлмөрийн нөхцөлтэй холбон үзсэн./60/ Энэ мэтээр их гүрнүүд улс орнуудын эдийн засагт эерэг болон сөрөг нөлөө үзүүлэх бодлого, шийдвэр гаргаж, өөрсдийн эрх ашгийг дээдлэсэн үйл ажиллагаа явуулсан хэвээр байна.

2. ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГ ХАНДЛАГА

Эдийн засгийн глобалчлалтай холбогдон гарч байгаа асуудлуудыг нийтэд нь ажиглахад улс орнууд ихэвчлэн хамтран ажиллах чиг хандлага давамгайлж байна. Хамтран ажиллах чиг хандлагын зарим нь глобалчлалын нөлөөг багасгахад чиглэгдэж байна. Тухайлбал 1989 онд Францын засгийн газар Европын Холбооны бусад гишүүдийг дуу, дүрс бичлэгийн соёлын бүтээгдэхүүнийг импортоор авах асуудалд өргөн хүрээтэй квот тогтоосон явдал юм. 1989 оны Европын Холбооны шийдвэрийн дагуу бол Европын телевизийн сувагийн гаргаж буй нийт нэвтрүүлгийн доор хаяж 50 хувь нь Европынх байх ёстой юм./ Францын хувьд нэвтрүүлгийн 60 хувь Европынх, 40 хувь нь Францынх байх ёстой шаардлага тавьж байв/ Францын засгийн газар 1993 оны кино бүтээгдэхүүний худалдааг чөлөөтэй болгох талаархи Уругвайн Раундын хэлэлцээрийн хүрээн дэх АНУ-тай хийсэн хэлэлцээндээ амжилт олсон юм./60/

Сүүлийн үед дээрхийн нэгэн адилаар АНУ болон Европын Холбооны түншүүд нь ГАТТ, ДХБ-ын далбаан дор худалдааг чөлөөлөх явдлыг хөдөлмөрчдийн эрх, бусад нөхцөлтэй холбон үзэх болсон./ 62/ Харин өнөөг хүртэл АНУ энэ чиглэлийнхээ дипломат зорилгодоо амжилт төдийлөн олохгүй байгаа юм. АНУ 1994 онд Уругвайн Раундын төгсгөлийн шатанд худалдаа, хөдөлмөрийн нөхцөлийг холбон үзсэн, улмаар 1999 онд Сийтл-д болсон ДХБ-ын сайд нарын дээд хэмжээний уулзалтын үеэр Европын түншүүдээ ДХБ, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын хамтарсан удирдлагын доор дээрх асуудлаар ажлын хэсэг байгуулах шахалт үзүүлсэн. Эдгээр оролдлогууд амжилт олоогүй бөгөөд учир нь хөгжиж буй орнууд ялангуяа Бразил, Энэтхэгийн үзэж байгаагаар АНУ-ын эдгээр оролдлого бол протекцианист үзэл юм. Хөгжиж буй орнуудын эмээж байгаа зүйл бол ДХБ-ын худалдааг чөлөөтэй болгох асуудалтай нийгмийн асуудлыг холбон үзэж олон жилийн туршид Америкийн үйлдвэрчний байгууллагын АНУ-ын засгийн газарт үзүүлж ирсэн дарамтын нэгэн адил нөхцөл үүснэ гэж үзэж байгаатай холбоотой юм. Хөдөлмөрийн стандартын тухай заалт нэвтрүүлбэл ДХБ-ын аль нэг гишүүн худалдааны хөнгөлөлтөөсөө татгалзах, тэр ч бүү хэл Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын хэд хэдэн конвенцид дурдсан олон улсын хөдөлмөрийн стандартыг хэрэгжүүлэхгүй байна гэсэн нэрийдлээр худалдааны хориг хүртэл авч дураар аашлах үүд хаалга нээгдэнэ гэж үзэж байна. Хөгжиж байгаа олон орны үзэж байгаагаар хөдөлмөрийн стандартын асуудал нь

хөгжиж буй орнуудын дотоод бодит байдлыг харгалзахгүй гадаадын стандартыг тулгаж хөгжиж буй орнууд харьцангуй давуу талаа алдахад ч хүргэж болзошгүй бөгөөд өөрсдийн амьжиргааны доогуур байдлаа харгалзан өөрсдөө асуудлаа шийдвэрлэхэд нь саад болж байна гэж үзэж байна. Ийнхүү хөдөлмөрийн стандартын тухай асуудал нь ДХБ-ын хүрээнд либералчлалыг гүнзгийрүүлэх бус харин хөгжингүй орнууд хөгжиж буй орнуудын эсрэг хандсан протекцианист бодлого болон хувирахад хүрээд байна.

Европын Холбооны нэвтрүүлгийн тухай шийдвэр, хөдөлмөрийн стандартын тухай АНУ-ын сонирхол зэрэг нь глобалчлалыг хязгаарлахад чиглэсэн хамтран ажиллах чиг хандлага гэж үзэж болох юм. Харин глобалчлалыг хязгаарлах бус харин удирдан чиглүүлэх талаар хамтран ажиллах чиг хандлага ч бас гарч байгааг тэмдэглэх нь зүйд нийцнэ. Тухайлбал, 1990 -ээд оны сүүлийн Ази, Орос, Бразилийг хамарсан санхүүгийн хямрал гарсан эхэн үед АНУ, Европын орнууд болон Япон ОУВС-гийн түншүүдтэйгээ хамтран уг хямралын байдлыг намжаахын тулд шинэ бодлого боловсруулах чиглэлээр хамтран ажилласан юм. “Олон улсын санхүүгийн шинэ бүтэц” буй болгохоор 1998 оны 10 дугаар сард ОУВС-гийн санал болгосон санаачилгууд нь мөнгө санхүүгийн хямралын эрсдэлийг багасгахад чиглэгдэж байгаа юм. Эдгээр саналуудад ОУВС-гийн түншүүд шинээр зах зээлийн эдийн засагт шилжиж буй орнуудын засгийн газруудад өөр өөрсдийн улс орны эдийн засгийн байдлын талаар тодорхой хугацаанд мэдээллээр /тухайлбал, нийт төлбөрийн чадвар, гадаад валютын нөөц гэх мэт/ хангах, банкны салбарын үйл ажиллагааг зохицуулах хүчтэй механизм бүрдүүлэх, мөн хөгжингүй орнуудын хувийн хөрөнгө оруулагчдыг дэмжиж, санхүүгийн тогтворгүй байдлыг намжаахад чиглэсэн зээлийн шинэ бодлого боловсруулах зэрэг үүрэг ноогдуулсан. Дээрхээс гадна ОУВС-гийн гишүүдэд ирээдүйд санхүүгийн хямрал гарах, тархах зэргээс хамгаалах үүднээс өөр хоорондоо нягт хамтран ажиллах үүргийг мөн нэгэн адил хүлээсэн билээ./63/

ДУГНЭЛТ

Өнөөгийн дэлхий ертөнцийн өнгө төрх, дэг жаягийг тодорхойлогч хүчнүүдийн дотроос хамгийн хүчтэй нь эдийн засгийн глобалчлал юм. Эдийн засгийн глобалчлал нь бидний хэрэглэж буй зүйл, бизнес хийж байгаа байдал, хадгаламжаа ашиглаж буй байдал, өөр хоорондоо хэрхэн харилцаж байгаа зэрэгт гүн гүнзгий нөлөө үзүүлж байна. Энэ нь нэг талдаа нийгмийн бүтцийг өөрчилж, хүмүүст амьдралын өргөн боломж нээж байхад нөгөө талдаа зарим хүмүүсийн амжиргааг нь алдагдуулахад хүргэж байна. Глобалчлал нь хувь хүмүүс алс холын өөр соёл иргэншилтэй танилцахад нь ихээхэн туслаж байгаа боловч зарим хувь хүмүүсийн хувьд өөрийн гэсэн соёл иргэншлээ гээхэд хүргэж байна. Глобалчлал нь орчин үед ганц хүний дарангуйллын дэглэм тогтноход улам төвөгтэй зардал чирэгдэл ихтэй болгож байгаагийн зэрэгцээ дэлхийн эдийн засагт адил тэгшээр оролцох зам сонгосон ард түмний бие даасан байдлаа хангах орон зайг улам бүр давчуу болгосоор байна. Глобалчлал нь зуу зуун жилээр зөрчилдөөнд оршиж ирсэн зах зээл болон түүний гишүүдийн хоорондын зөрчилийг улам гүнзгийрүүлсээр байна. Зах зээл нь шинэ өсөлт, шинэ хөгжил, шинэ хэрэглээ, амжиргааны шинэ өндөр түвшинг буй болгосоор байна. Гэвч нөгөө талаар өсөх унахын шинэ эрсдэл буй болгож, ихээхэн үр ашиг авчирч байгаагаас гадна мөн тэр хэмжээний тэгш бус байдлыг буй болгож байна. Глобалчлал нь зах зээлийн хөгжлөөр нийгэм, соёлын зохицол, эв нэгдлийг хэрхэн хангах вэ гэсэн асуудал бидний өмнө тавьж байна. Аж үйлдвэржсэн болон шинээр зах зээлд шилжиж буй орнуудын нийгэм, эдийн засгийн эрчимтэй харилцаанаас үүдэн гарч байгаа нийгмийн бүхмдлыг хэрхэн зохицуулахаас эдийн засгийн глобалчлалын далайц түүний тогтвортой байдал тодорхойлогдох болно. Ийнхүү дээр дурдсан хүчин зүйлүүд, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал, түүний өрнөл хөгжил, өсөлт бууралт нь шинэ зууны өнгө төрх, хэв маягийг илтгэн харуулж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Paul Krugman, "Growing World Trade: Causes And Consequences," *Brooking Papers On Economic Activity*, Issue 1 (1995)
2. U.S., Council on Economic Advisers, *Economic Report of the President* (Washington: GPO, February 2000), p.203.
3. Robert C.Feenstra, "Integration of Trade and Disintegration of Production in the Global Economy," *Journal of Economic Perspectives* 12 (Fall 1998) pp.34-35;
4. CEA, *Economic Report of the President 2000*, p. 203;
5. Krugman, "Growing World Trade", p.5
6. Feenstra, "Integration of Trade", p. 37
7. CEA, *Economic Report of the President 2000*, p. 205.
8. Krugman, "Growing World Trade", p.22
9. Baldwin and Martin, "Two Waves of Globalization," p.17.
10. *Economic Report of the President 2000*, p. 205.
11. U.S., Council on Economic Advisers, *Economic Report of the President* (Washington: GPO, February 1999), p.224.
12. Maurice Obstfeld, "The Global Capital Market: Benefactor or Menace?," *Journal of Economic Perspectives* 12 (Fall 1998), p.11-12;
13. Obstfeld, "The Global Capital Market", pp 12-13;
14. *Economic Report of the President 2000*, p. 206.
15. Bordo, Eichengreen, and Irwin, "Globalization Today," p.62.
16. *Economic Report of the President 2000*, Box 6-1, pp. 207-207.
17. Bordo, Eichengreen, and Irwin, "Globalization Today," p.16.
18. *Economic Report of the President 2000*, p. 209; and Bordo, Eichengreen, and Irwin, "Globalization Today," p.17.
19. *Economic Report of the President 2000*, pp. 209-210.
20. On the manner in which multinational firms have learned how to use advanced technology to manage their worldwide business operation,
21. Krugman, "Growing World Trade", p.7.
22. *Economic Report of the President 2000*, pp. 212.
23. John Gerard Ruggie footnote.

24. Kenneth N.Waltz, "Theory of International Politics" (Addison-Wesley Publishing Co., 1979), pp.195-96.
25. Thomas L.Friedman, *The Lexus and the Olive Tree* (New York: Farrar, Straus and Giroux, 1999), p.197;
26. *Ibid.*, p.198; for empirical evidence in support of the view that growing economic interdependence,
27. For this argument, Kenneth Waltz, "The Myth of National Interdependence," in Charles P.Kindleberger, ed., *The International Corporation* (Cambridge: MIT Press 1970);
28. Christopher Gelpi and Joseph M.Grieco, "Democracy, Interdependence, and the Liberal Peace," Unpublished Manuscript (March 2000).
29. Paul A.Papayoanou, "Interdependence, Institutions, and Balance of Power," *International Security* 20 (Spring 1996), pp.42-76.
30. Friedman, *Lexus and Olive Tree*, p.11.
31. Such crisis, it should be emphasized, are not restricted to emerging-market economies alone: for example, when the currency values and Italy and France came under attack in 1992 after they and other European Union countries set a path for Economic and Monetary Union (EMU), the Swedish currency also came under pressure even though Sweden had not proposed to join EMU and indeed was not even then a member of the European Union!
32. For a review of these crisis, U.S., Council on Economic Advisers, *Economic Report of the President* (Washington: GPO, February 1999), pp.225-235.
33. International Monetary Fund, *World Economic Outlook* (Washington, October 1999), pp.64-67.
34. Ianthe Jeanne Dugan, "More Losses Reported in Fund Collapse" *Washington Post*, September 26.1998, p.C1, available on the World Wide Web through Lexis-Nexis.
35. "Statement by William J. McDonough, President, Federal Reserve Bank of New York, Before the Committee on Banking and Financial Services, U.S. House of Representatives", October 1, 1998, and reprinted in the *Federal Reserve Bulletin* (December 1998,) and available on the World Wide Web through info Trac;
36. "Statement by Alan Greenspan, Chairman, Board of Governors of the Federal Reserve System, Before the Committee on Banking

- and Financial Services, U.S. House of Representatives”, October 1, 1998, and reprinted in the Federal Reserve Bulletin (December 1998,) and available on the World Wide Web through info Trac; pp. 1-2.
37. For a theoretical analysis of this differential response of Europe and America to economic globalization, Krugman, “Growing World Trade”, pp.14-19.
 38. Baldwin and Martin, “Two Waves of Globalization,” p.20:
 39. IMF, October 1999 WEO, p.72.
 40. Baldwin and Martin, “Two Waves of Globalization,” p.21;
 41. Rodrik, Has Globalization Gone Too Far?, p.17,
 42. Feenstra, “Integration of Trade”, pp.41-42.
 43. Rodrik, Has Globalization Gone Too Far?, pp.16-25,
 44. Friedman, Lexis and Olive Tree, pp.233, 309.
 45. Tyler Cowen, “French Kiss-Off, Reason 30 (July 1998), available on the World Wide Web at ProQuest, P.1;”
 46. Culture Wars, “Economist, Sept. 12 1998 available on the World Wide Web through Info Trac, p.1.
 47. Ibid., p.2.
 48. For a helpful overview, William Watson, Globalization and the Meaning of Canadian Life (Toronto: University of Toronto Press, 1998).
 49. IMF, October 1999 WEO, pp.52.
 50. Sebastian Edwards, “The Americas: Capital Controls Are Not the Reason for Chile Success,” Wall Street Journal, April 3, 1998, p.A19, available on the World Wide Web through ProQuest.
 51. IMF, October 1999 WEO, pp.54-56.
 52. Cowen, “French Kiss-Off,” pp.6-8; and van Elteren, “GATT and Beyond,” p.1.
 53. World Trade Organization, “Canada-Certain Measures Concerning Periodicals: Report of the Panel,” WTO Document WT/DS31/R, available on the World Wide Web through the WTO website, www.wto.org;
 54. I.M.Destler, a long-time student of U.S. trade politics, suggested at the end of the 1990s that U.S. trade policy was “on hold”; Destler, “Trade Policy at a Cross Roads,” Brookings Review (Winter 1999), pp.26-30, and available on the World Wide Web through ProQuest.

55. "The Sinking of the MAI," *Economist*, March 14, 1998, available on the World Wide Web at www.economist.com (archive).
56. David E. Sanger, "US Resistance Plan to Remove Tariffs for Poor Nations," *New York Times*, April 9, 2000, p.1.
57. Thomas E. Skilton, "GATT and Environment in Conflict: the Tuna-Dolphin Dispute and the Quest for an International Conservation Strategy," *Cornell International Law Journal* 26 (1993): 455-494.
58. Ronald Mitchell, "International Oil Pollution of the Oceans," in Peter M. Haas, Robert O. Keohane, and Marc A. Levy, eds., *Institutions for the Earth: Sources of Effective International Environmental Protection* (Cambridge: MIT Press, 1993), pp.183-247.
59. Ethan Barnaby Kapstein, "Between Power and Purpose: Central Bankers and the Politics of Regulatory Convergence," in Peter M. Haas, ed., *Knowledge, Power, and International Policy Coordination*, special issue of *International Organization* 46 (Winter 1992), pp.265-288.
60. Virginia A. Leary, "Workers" Rights and International Trade: the Social Clause, in Jagdish Bhagwati and Robert E. Hudec. Eds., *Fair Trade and Harmonization: Prerequisites for Free Trade? Volume 2, Legal Analysis* (Cambridge: MIT Press, 1996), pp.210-214.
61. Elteren, "GATT and Beyond," pp.1-2.
62. Leary "Workers" Rights and International Trade," and Eddy Lee, "Globalization and Labor Standards: a Review of Issues," *International Labor Review* 136 (1997), available through the ILO website at www.ilo.org.
63. For a helpful overview of these and other proposals to the construction of a "new international financial architecture," *Economic Report of the President, 1999*, pp.267-305.